



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 1/570

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.7, 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, 2023 оны “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих нэрлэсэн жил зарлах тухай” 11 дүгээр тогтоол, 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих нэрлэсэн жил 2024”-ийн хүрээнд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, “Хүүхдийн элч”-ийн зүгээс Хөвсгөл аймгийн хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн өмнө тулгамдсан асуудлуудыг тодорхойлон шийдвэрлэх арга замын талаар хүүхдүүдийн дуу хоолойг сонсох зорилгоор “Хүүхдээ сонсьё” уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулахад 2,974,800 (хоёр сая есөн зуун далан дөрвөн мянга найман зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2,974,800 (хоёр сая есөн зуун далан дөрвөн мянга найман зуу) төгрөгийг Гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах зардлаас гаргаж зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

